

МОНГОЛ УЛС  
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ  
“ТАЛЫН ХӨРС” ХХК

АРХИВ № 11/2023

ЗТ18-767/20

УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 35-р  
ХОРООНЫ НУТАГТ БАРИГДАХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО  
ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХАД ЗОРИУЛСАН  
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДУГНЭЛТ

Улаанбаатар хот. 2023 он

МОНГОЛ УЛС  
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ  
“ТАЛЫН ХӨРС” ХХК

АРХИВ № 11/2023

ЗТ18-767/20



УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 35-р  
ХОРООНЫ НУТАГТ БАРИГДАХ ХАТUU ХУЧИЛТТАЙ АВТО  
ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХАД ЗОРИУЛСАН  
ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДУГНЭЛТ

Захирал

Хянасан ТАЛЫН ХӨРС  
ХХК

Боловсруулсан



Б.Баатарцогт

Б.Баатарцогт

Н.Баттөгс

Улаанбаатар хот. 2023 он

## ГАРЧИГ

<b>I. ОРШИЛ</b>	3
<b>II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b>	4
<b>II.1. Байршил ба техникийн тодорхойлолт</b>	4
<b>II.2. Уур амьсгал</b>	4
<b>II.3. Геологийн тогтоц</b>	7
<b>II.4. Геоморфологийн хэв шинж</b>	7
<b>II.5. Гидрогеологийн нөхцөл</b>	7
<b>III. УЛ ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР</b>	8
<b>IV. ДҮГНЭЛТ</b>	10
<b>V. АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	11
<b>VI. ЦООНГОЙН КАТАЛОГ</b>	12
<b>VII. ЦООНГОЙН БИЧИГЛЭЛ</b>	12
<b>VIII. ФОТО</b>	13

### **ХАВСРАЛТУУД**

**Баримт материалын зураг**

**Инженер-геологийн зүсэлт**

**Ул хөрс, чулуулгийн физик үзүүлэлтүүдийн хүснэгтүүд**

## I. ОРШИЛ

Авто замын зураг төслийн "Эс Ар Pi инженер консалтинг Монголиа" ХХК-ийн захиалга, тус компанийтай байгуулсан ИГ 2023/11 тоот ажил гүйцэтгэх гэрээ, АД-11 тоот ажлын даалгаврын дагуу Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 35-р хорооны нутагт баригдах хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулахад зориулсан инженер-геологийн судалгааны ажлыг "Талын хөрс" ХХК 2023 онд гүйцэтгэв.

Инженер-геологийн хээрийн судалгааны ажлаар инженер Б.Баатарцогт, өрмийн мастер, жолооч Ж.Наранхүү, Л.Эрдэнэбат, туслах ажилчин Ч.Баярмагнай нарын бүрэлдэхүүнтэй хэсэг 2023 оны 02 сарын 11-нд ПБУ-50 маркийн өрмийн машинаар эргэлтэй өрөмдлөгийн аргаар дээжлэлттэй төлөвлөж буй авто замын зурvasын дагууд 0.8-4.0 м гүнтэй 3 цооногийг, нийт 7.8 уртааш метр өрөмдлөгийн ажил явууллаа.

Өрөмдсөн цооногуудаас илэрсэн ул хөрс, чулуулгийн ширхгийн бүрэлдэхүүн, физик шинж чанар тодорхойлох зорилгоор 5 ширхэг дээж авч, шинжилгээг "Инжгеотех" ХХК-ийн лабораторид инженер А.Ариунзаяа хийллээ.

Зурvasын дагуу өрөмдсөн цооногуудын байршлыг захиалагч байгууллагаас ирүүлсэн байр зүйн зурагт буулгаж, өндөржилтийг дагуу зүсэлтийн зургаас авлаа.

Хээрийн өрөмдлөгийн тэмдэглэл, лабораторийн шинжилгээний үр дүн, өмнөх судалгааны материал зэргийг нэгтгэн, шинээр баригдах хатуу хучилттай авто замын барилгын ажлын зураг төсөв боловсруулахад зориулсан инженер-геологийн судалгааны ажлын дүгнэлтийг инженер Н.Баттөгс боловсрууллаа.

Судалгааны ажилд холбогдох эх материалуудыг дүгнэлтийн эх хувьд хавсарган тус компанийн архивд хадгалав.

## II. СУДАЛГААНЫ РАЙОНЫ ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### II.1. Байршил ба техникийн тодорхойлолт

Шинээр барих авто замыг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 35-р хорооны нутагт Нарангийн гудамжнаас салаалж, 35-р хорооны барилга хүртэл 1.0 км төлөвлөжээ.



### II.2. Уур амьсгал

Судалгааны талбайн уур амьсгалын үзүүлэлтийг "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" (АЗУАГН 2.01.01-2004)-ийн дагуу тодорхойлов. Төлөвлөж буй авто замын зурvas Монгол орны авто замын уур амьсгалын мужлалаар IIВ бүсэд орших ба тодорхойлтуудыг дор үзүүлэв.

Монгол орны авто замын бүсүүдийн уур амьсгалын, геотехникийн үзүүлэлт

## Хүснэгт II-1

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Уур амьсгалын болон хөрсний нөхцөл
II Авто замын уур амьсгалын хээрийн бүс	IIВ. Уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс	-Авто замын уур амьсгалын хуурайхүйтэн сэруүвтэр хахир, хуурайдуу сэруүвтэр хүйтэн бэсрэг уулт хээр, хээр талын хахирлаг дэд бүс	Тал хээрийн дэд бүс нь улирлын гүн хөлдөлтгэй, овойлт болон суулт үүсгэнэ. Цас нимгэн, хахир өвөлтэй. Газар хөдлөлийн 6-7 балл

IIВ бүсийн авто замын уур амьсгалын улирлын үргэлжлэх хугацаа\*

## Хүснэгт II-2

Эхлэх	Дуусах	Өвөл		Хавар		Зун		Nамар
		Үргэлжлэх хөдөлжин хоног	Дуусах	Үргэлжлэх хөдөлжин хоног	Дуусах	Үргэлжлэх хөдөлжин хоног	Дуусах	Үргэлжлэх хөдөлжин хоног
1-9.XI	15-24.II	126-143		6-12.VI	45-52	8-19.IX	112-156	44-54
5.XI	19.III	134		9.V	48	13.IX	129	49

Тайлбар: \* өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэх намрын дуусах хугацаа болно.

Хөрс агаарын температур ( $^{\circ}\text{C}$ )

## Хүснэгт II-3

Хөрсний гадаргын температур, $^{\circ}\text{C}$				Агаарын орчны дундаж температур, $^{\circ}\text{C}$		
Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0 $^{\circ}$ нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн халуун сарын	Хамгийн хүйтэн сарын
+0...+3	60-65	-41...-45	250-350	-2...+2	-20...-25	15...20

Тайлбар: \* 0 $^{\circ}\text{C}$  нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд доод хязгаарыг авав.

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

## Хүснэгт II-4

Хөлдөлт			Гэсэлт		
Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
20-30.X 25.X	15.III-30.IV 5.IV	120-195 160	15.III-10.IV 25.III	15.IV-31.V 23.IV	20-50 35

Барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон боломжгүй улирлын үе

Хүснэгт II-5

Дулааны улирал*			Хүйтний улирал
Эхлэл	Дуусах	Хоног	Хоног
10.IV	19.X	192	173

Тайлбар: \* Авто замын үйлдвэрлэлийн хүйтэн улирлын эх нь дулааны улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулаан улирлын эх болдог.

Хур тунадасны хэмжээ

Хүснэгт II-6

Хур тунадасны нийлбэр, мм							
Өвөл	Хавар	Зун	Намар	Жил	1 хоногт орох борооны хангамж,	Борооны хамгийн их орох эрчим мм/мин	
					мм		
3-10	15-30	150-200	20-35	220-250	80	104	1-1.50

Гол мөрний гадаргын усны горимын зарим үзүүлэлт

Хүснэгт II-7

Гол мөрний гадаргын усны							
Нягтийл	Жилийн дундаж урсац, л/сек	Дундаж урсын давхраа, мм	Хаврын шар усны Үерийн хамгийн их урсац, мм	Модуль, л/сек ам.км	Мөслийн хамгийн их зузааны дундаж, см	Мөс хадаалах хугацаа	Мөс задрах хугацаа
0.04-0.2	1-2	25-100	10-100	0.4-0.8	100-125	10-20.XI	21.V-с эрт

Халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт II-8

Асфальт болон замын хучилт		
Эхлэх	Дуусгах	Хоног
18.IV-16.V (2.V)	15.III-19.IX (1.IX)	91-154 (122)

Хүйтэн, бүлээн асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт II-9

Асфальт болон замын хучилт		
Эхлэх	Дуусгах	Хоног
3.III-30.III (16.III)	30.X-4.XII (15.XI)	220-278 (250)

### **II.3. Геологийн тогтоц**

Судалгааны зурвасын дагуу Плейстоцен-Голоцены настай, делюви-пролювийн гаралтай хайргархаг шавранцар ул хөрс, доод-дунд Карбоны настай, тунамал гаралтай элсэн чулуу илэрсэн.

### **II.4. Геоморфологи хэв шинж**

Төлөвлөж буй авто замын зурvas уулын бэл хормойн гаралтай, хуримтлал болон байран хэв шинжит гадаргууд хамарагдана.

### **II.5. Гидрогоеологийн нөхцөл**

Хээрийн судалгааны үед өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй.

### III. УЛ ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

Авто замын зурвасын дагуу техноген гаралтай асгамал хөрсний доороос Плейстоцен-Голоцены настай, делюви-пролювийн гаралтай хайргархаг шавранцар ул хөрс, доод-дунд Карбоны настай, тунамал гаралтай элсэн чулуу илэрснийг тэдгээрийн нас, гарал үүсэл зэргийг харгалзан инженер-геологийн 2 элементтэд ангилан, физик, механик шинж чанарыг дор үзүүллээ.

#### ИГЭ-1. Хайргархаг шавранцар ул хөрс

Хайргархаг шавранцар ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүн, /%/:

- хайрга	36.2
- элс	43.6
- тоос	7.5
- шавар	12.7

Хайргархаг шавранцар ул хөрсний физик үзүүлэлтүүд:

- байгалийн чийг	0.065
- урсалтын хязгаар дахь чийг	0.297
- имрэгдлийн хязгаар дахь чийг	0.200
- уян налархайн тоо	0.097
- хатуу хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	2.72
- байгалийн нягт, г/см <sup>3</sup>	1.95
- хуурай хэсгийн нягт, г/см <sup>3</sup>	1.83
- сувшил, %	32.66
- сувшилийн коэффициент	0.486
- чийглэгийн зэрэг	0.37
- консистенц	-1.43

Хайргархаг шавранцар ул хөрсний механик утгууд:

Хэв гажилтын модуль	E=108 МПа
Дотоод үрэлтийн өнцөг	$\phi=32^0$
Зууралдлын хүч	C=0.045 МПа
Тооцооны эсэргүүцэл	R <sub>0</sub> =400 кПа

Хайргархаг шавранцар ул хөрсний хатуулгийн зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад III байна.

Хайргархаг шавранцар ул хөрс сул овойлттой (хөрсний бүлэг II, 1.5 м гүн хөлдөх үеийн харьцангуй овойлтын дундаж хэмжээ 2-4%) хөрсөнд нормчлогдоно.

## ИГЭ-2. Элсэн чулуу

Доод-дунд Карбоны настай, тунамал гаралтай, цайвар саарал өнгөтэй элсэн чулууны физик-механик шинж чанарын үзүүлэлтүүд:

- Чулууны нягт, г/см <sup>3</sup>	
- өгөршөөгүй	2.60
- өгөршсөн	2.42
- Өгөршлийн итгэлцүүр	Kwr=0.93
- Өгөршлийн зэрэг	сулавтар
- Хатуулгийн зэрэг	VII
- Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, Rc, МПа	
- усаар ханасан үед	27-15
- байгалийн чийгтэй үед	50-30

**IV. ДҮГНЭЛТ**

1. Судалгааны зурvasын дагуу 2 төрлийн ул хөрс, чулуулаг илэрсэн, геоморфологийн 2 төрлийн гадаргууд хамарагдана, хөрсний ус илрээгүй зэргээс үзэхэд инженер-геологийн энгийн нөхцөлтэй талбайд хамаарна.

2. Зурvasын дагуу тархсан ул хөрсний механик утга:

Хөрсний төрөл	Модуль E, ГПа	Хэв гажилтын модуль, МПа	Дотоод үрэлтийн өнцөг, градус	Зууралдлын хүч, МПа	Тооцооны эсэргүүцэл, кПа
		Ф	С	Ro	
Хайргархаг шавранцар	1	108	32	0.045	400

3. Зурvasын дагуу тархсан ул хөрсний овойлтын хүч, улирлын хөлдөлтийн норматив гүн, газар шорооны ажлын зэрэг:

Хөрсний төрөл	Овойлтын зэрэг	Улирлын хөлдөлтийн норматив гүн, м	Газар шорооны ажлын зэрэг
Хайргархаг шавранцар	Сул овойлттой	3.5	III
Элсэн чулуу	-	-	VII

4. Судалгааны район газар хөдлөлтийн балл:

Хамрах хэсэг	Балл	Хөрсний оргил хурдатгал, см/с <sup>2</sup>
ПК0+000-ПК0+460	VIII	143-190
ПК0+460-ПК1+000	VII	110-142

Дүгнэлт боловсруулсан

Инженер  Н.Баттөгс



## V. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл. АЗУАГН 2.01.01-2004
2. Барилгын инженер геологи, геотехникийн судалгааны ажил. БНБД 11-03-21
3. Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм. БНБД 50-01-16
4. Газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх. БНБД 22-01-21
5. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан, дүгнэлт бичих дүрэм. БД 11-107-11
6. Монгол орны нутаг дэвсгэрт шугаман барилга байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар. БД 11-107-10
7. Ул хөрсний ангилал. MNS 3263:2014
8. Байран гаралтай ул хөрсөнд инженер геологийн судалгаа хийх заавар. БД 11-116-16

## VI. ЦООНГОЙН КАТАЛОГ

Цооногийн дугаар	Цооногийн гүн, м	Амсрын өндөр, м	Солбицол		Хөрсний усны түвшин, м		Өрөмдсөн огноо
			X	Y	илэрсэн	тогтсон	
Ц-1	4.00	1307.34	631994	5309651			2023.02.11
Ц-2	3.00	1335.34	632221	5309970			2023.02.11
Ц-3	0.80	1368.36	632485	5310143			2023.02.11

## VII. ЦООНГОЙН БИЧИГЛЭЛ

### Цооног 1

Гүн 4.00 м  
Диаметр 168 мм

Өндөржилт 1307.34 м  
Өрөмдсөн 2023.02.11

1. Ахуйн болон барилгын хогтой асгамал хөрс (0.00-0.50)/0.50
2. Плейстоцен-Голоцены настай, делюви-пролювийн гаралтай, бор шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй хайргархаг шавранцар ул хөрс (0.50-3.50)/3.00
3. Доод-дунд Карбоны настай, тунамал гаралтай, цайвар саарал өнгөтэй, сувалтар өгөршсөн элсэн чулуу (3.50-4.00)/0.50

Хөрсний ус илрээгүй.

### Цооног 2

Гүн 3.00 м  
Диаметр 168 мм

Өндөржилт 1335.34 м  
Өрөмдсөн 2023.02.11

1. Плейстоцен-Голоцены настай, делюви-пролювийн гаралтай, бор шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй хайргархаг шавранцар ул хөрс (0.00-1.40)/1.40
2. Доод-дунд Карбоны настай, тунамал гаралтай, цайвар саарал өнгөтэй, сувалтар өгөршсөн элсэн чулуу (1.40-3.00)/1.60

Хөрсний ус илрээгүй.

### Цооног 3

Гүн 0.80 м  
Диаметр 168 мм

Өндөржилт 1368.36 м  
Өрөмдсөн 2023.02.11

1. Доод-дунд Карбоны настай, тунамал гаралтай, цайвар саарал өнгөтэй, сувалтар өгөршсөн элсэн чулуу (0.00-0.80)/0.80

Хөрсний ус илрээгүй.

Хээрийн тэмдэгдэл хөтөлсөн:


Инженер

Б.Баатарцогт

### VIII. ФОТО



Зураг 1. Зурвасын дагуух өрөмдлөг



Зураг 2. Зурвасын дагуух өрөмдлөг

## УЛ ХӨРСНИЙ ФИЗИК ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЛАБОРАТОРИД ТОДОРХОЙПСОН НЭГДСЭН ХУСНЭГТ

Лабораторийн нийт номын тоо, шт.	Лабораторийн нийтийн номын тоо, шт.	Лабораторийн нийтийн хувь, %	Лабораторийн нийтийн бүрэлдэхүүн, %	Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн, %										
				≤0.005	0.01-0.005	0.05-0.01	0.1-0.05	0.25-0.1	0.5-0.25	1-0.50	2-1.0	5-2.0	10-5.0	>10
22/012	Ц-2	1.0	7.1	12.2	16.6	8.8	10.2	11.3	8.6	6.2	3.3	5.6	10.1	0.058
22/013	Ц-1	2.6	4.8	9.2	16.8	14.2	9.7	5.5	11.1	6.7	3.6	4.1	14.3	0.071
22/014	Ц-1	1.2	3.2	16.5	22.1	10.2	6.5	7.1	6.6	8.2	4.2	1.6	13.8	0.067
22/015	Ц-3	0.5												
22/016	Ц-2	2.5												

А.Ариунзаяа



Лабораторийн инженер

УДК 62(07) 7.5. ФИЛОСОФИЯ И ПСИХОЛОГИЯ

Үл хөрсний ширхгийн бүрэлдэхүүн, %	Хайр, хайрга	Элс	Тоос	Шавар	Барийн нийт, %
>10					0.005
10-5.0					0.01-0.005
5-2.0					0.05-0.01
2-1.0					0.1-0.05
1-0.50					0.25-0.1
0.5-0.25					0.5-0.1
0.1-0.05					0.01-0.005
0.05-0.01					0.005
Yжн наалдрхай	Үргэлжлэх эзэртэй, W <sub>U</sub>	Империалистичны эзэртэй, W <sub>P</sub>	Үзүүлэх эзэртэй, I <sub>P</sub>	Үзүүлэх эзэртэй, I <sub>U</sub>	Барийн нийт, P <sub>B</sub>
Нийт, г/см <sup>3</sup>	Xээчилж буй, P <sub>W</sub>	Xээчилж буй, P <sub>D</sub>	Xээчилж буй, P <sub>D</sub>	Xээчилж буй, P <sub>W</sub>	Xээчилж буй, P <sub>D</sub>
	Хийж буй, Ps	Хийж буй, Ps	Хийж буй, Ps	Хийж буй, Ps	Хийж буй, Ps

### ИГЭ-1. Хайрлархаг шавранцар ул хөрс

ML3-2. Ejecta Flyway

Хамгийн их угта  
Хамгийн бага угта  
Дундаж угта

Боловсруулсан

H. Hapdei